



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар Б/44

Хэрлэн сум

Б.Амгаланбатад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 65 дугаар зүйлийн 65.3.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтын ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх заалтыг зөрчсөн тухай аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 254/A2370454 дүгээр албан шаардлагын дагуу Баянхутаг сумын Засаг дарга Б.Амгаланбатад сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Баянхутаг сумын Засаг дарга Б.Амгаланбатад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ